



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/54

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6, Хууль сахиулахын их сургуулийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.2-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль сахиулахын их сургуулийн "2017-2018 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга /цагдаагийн дэд хурандаа Л.Мандах/, Соёл, олон нийттэй харилцах албаны дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Энхболд/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал /цагдаагийн хурандаа Б.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАХИРАЛ, ПРОФЕССОР,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

С.БААТАРЖАВ

ХУУЛБАР ҮНЭН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

В.БЯМБАСҮХ



Хууль сахиулахын их сургуулийн захирлын
2017 оны 02 сарын 29 ны өдрийн 157 дугаар
тушаалын хавсралт

2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВРЫН
ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

УХД0272 1701282

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Хууль сахиулахын их сургууль /цаашид “Их сургууль” гэх/-ийн 2017-2018 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтыг зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Элсэлтийн шалгалтыг зохион байгуулахад Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, мөн сайдын 2014 оны А/143 дугаар тушаал /Элсэлтийн чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай/, мөн сайдын 2016 оны А/86 дугаар тушаал /Ерөнхий шалгалтын үндэсний хэмжээний босго тогтоох тухай/, Хууль зүйн сайдын 2015 оны А/148 дугаар тушаалаар баталсан “Хууль сахиулахын их сургуулийн дүрэм”, мөн сайдын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуульд суралцагч элсүүлэн суралцуулах журам”, захиалагч агентлаг, байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомж болон энэ журмыг баримтална.

1.3. Элсэлтийн шалгалтыг Элсэлтийн шалгалтын комисс /цаашид “Комисс” гэх/ зохион байгуулна. Захиалагч агентлаг, байгууллагатай зөвшилцөн Комиссын бүрэлдэхүүнд төлөөллийг оролцуулан Их сургуулийн захирлын тушаалаар батална.

1.4. Комиссын дарга элсэлтийн шалгалтын бэлтгэл ажлыг хангах, нэмэлт шалгалтын агуулга, даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг байгуулж, өдөр тутмын удирдлагаар хангана.

1.5. Элсэлтийн шалгалтад элсэхийг хүсэгчийн төлөөлөл болон бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжийн хүрээнд хөндлөнгийн хяналт тавина.

1.6. Элсэлтийн шалгалтын үйл ажиллагааг Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Хилчний гудамж /бүсчлэлийн код 13260/-д байрлах Их сургуулийн байранд /цаашид Их сургуулийн байрлал гэх/ зохион байгуулна.

1.7. Элсэлтийн шалгалттай холбогдох мэдээллийг Их сургуулийн “www.leu.gov.mn” цахим хуудсанд байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Хоёр. Элсүүлэх хөтөлбөрийн чиглэл

2.1. Их сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилд дараах бакалаврын хөтөлбөрүүдэд элсүүлэн суралцуулна.

№	Хөтөлбөрийн нэр, индекс	Элсүүлэх хяналтын тоо		Шалгалтын чиглэл	
		Нийт	Үүнээс: сонгон шалгаруулалтаар	Суурь	Хавсарга
Өдрийн сургалт					
1	“Цагдаа-хууль сахиулах ажил” /D103201/	180	Эрэгтэй-120	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 560	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 480
2	Шүүхийн шинжилгээ-хууль сахиулах ажил / D103204/	30	Эрэгтэй-20	Математик <u>Босго оноо:</u> 560	Нийгмийн тухай мэдлэг, гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
3	“Хилийн алба” /D103802/	20	Эрэгтэй-10	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400

4	“Эдийн засаг” /D031101/ “Хилийн цэргийн ар тал-эдийн засаг”	20	Эрэгтэй-10	Математик <u>Босго оноо:</u> 480	Гадаад хэл, Физик /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
5	“Сэтгэл судлал” /D031301/ “Цэргийн сэтгэл судлал”	20	Эрэгтэй-10	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
6	“Шалган нэвтрүүлэх алба- хууль сахиулах ажил” /D103206/	20	Эрэгтэй-10	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
7	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил” /D103202/	25	Эрэгтэй-20	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
8	“Аюулгүй байдал” /D103801/	20	Эрэгтэй-10 Эмэгтэй-5	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 560	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
9	“Нийгмийн ажил” /D092301/	20	Эрэгтэй-10 Эмэгтэй-5	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 480	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
10	Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба /D103205/	25	Эрэгтэй-20	Математик <u>Босго оноо:</u> 480	Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400
11	Эрх зүй /D041201/	60	Хүйс харгалзахгүй-60	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 400	ЭЕШ өгсөн нэг хичээл <u>Босго оноо:</u> 400
Эчнээ сургалт					
12	Цагдаа-хууль сахиулах ажил D103201 /5 жил/	70 алба хаагч (Бүрэн дунд боловсролтой)		Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн нэг хичээлийг сонгох <u>Босго оноо:</u> 400	
13	Хилийн алба D103802 /5жил/	30 алба хаагч (Бүрэн дунд боловсролтой)			
14	Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба D103205 /5 жил/	30 алба хаагч (Бүрэн дунд боловсролтой)			
15	Цагдаа-хууль сахиулах ажил D103201 /3 жил/	36 алба хаагч (Дээд боловсролтой)	Нийгмийн тухай мэдлэг 60 хувь	Гадаад хэл 40 хувь	
16		Эрэгтэй-50 иргэн (Дээд боловсролтой)		Өмнөх бакалаврын дипломын голч дүн 3.2-оос доошгүй	
17	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил D103202 /3 жил/	30 алба хаагч (Дээд боловсролтой)		Нийгмийн тухай мэдлэг 60 хувь	Гадаад хэл 40 хувь
18	Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба D103205 /3 жил/	30 алба хаагч (Дээд боловсролтой)		Математик 60 хувь	Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл /сонгох/ 40 хувь

2.2. Агентлаг, байгууллагын захиалгаар сонгон шалгаруулалтгүй элсэх алба хаагч, иргэний хувьд элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн нэг хичээлийн босго оноо 400 байна.

2.3. Их сургуулийн элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлсэн иргэдийг элсүүлэх хөтөлбөр тус бүрээр элсэлтийн ерөнхий шалгалтын сонгогдсон хичээлүүдийн онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоог 30 хүртэл хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны иргэд нэмэлт шалгалт, судалгаанд хамрагдах эрхтэй.

(Жишээлбэл, нэг хөтөлбөрөөр элсүүлэх хяналтын тоог 100 байхаар баталсан тохиолдолд цахим бүртгэлд бүртгүүлсэн элсэхийг хүсэгчдийн жагсаалтын эхний 130 хүртэл элсэхийг хүсэгч нэмэлт шалгалтад орох эрхтэй болно.)

2.4. Өдрийн сургалтад элсэхийг хүсэгч иргэдээс дараах чиглэлүүдээр нэмэлт шалгалт авна.

№	Нэмэлт шалгалтын чиглэл	Шалгуур	Зохион байгуулах хугацаа	Газар
1	Эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн ерөнхий шалгуур	- Эрүүл мэндийн хувьд цэргийн албанд тэнцэх /Монгол Улсын Батлан хамгаалах, Хууль зүй, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2016 оны А/115, А/174, А/194 дугаар тушаал/ - Шивээсгүй - Бие эрхтний зөв хөгжилтэй, биеийн ил харагдах хэсэгт 20x05мм-ээс том сорвигүй байх	2017.07.03- 2017.07.05	Их сургуулийн байрлалд
2	Бие бялдрын хөгжил	Хүч, тэсвэр, уян хатан, хурд, авхаалж самбаа гэсэн 5 чанар тус бүрээр зохих шалгуур хангасан байх	2017.07.05- 2017.07.06	Их сургуулийн байрлалд
3	Сэтгэл зүйн бэлтгэл	Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэн бодох чадвар, мэргэжлийн сонголт хийж буй сэтгэл зүйн хандлагын түвшин		Цэргийн хэргийн бэлтгэл сургалтын явцад
4	Ёс зүй, бие хүний хандлагын төлөвшил	Ял шийтгэлгүй, /цагдаа-хууль сахиулах ажил хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь ял шийтгэгдэж байгаагүй/ захиалагч агентлаг, байгууллагын зан байдал, хандлага, ёс зүйн судалгаанд тэнцсэн байх	2017.07.10- 2017.08.20	Цэргийн хэргийн бэлтгэл сургалтын явцад
5	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл	Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалтад тэнцсэн байх	2017.07.24- 08.25	Гүнжийн хоолой дахь сургалт, дадлагын төв

2.5. “Эрх зүй” хөтөлбөрт элсэхийг хүсэгчдээс нэмэлт шалгалт авахгүй.

Гурав. Элсэхийг хүсэгчид тавих шаардлага

3.1. Элсэхийг хүсэгч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

3.1.1. Бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой элсэхийг хүсэгч нь 2015 оноос хойш монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгсөн байх;

3.1.2. Сонгосон хөтөлбөрт хамаарах хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь энэ журмаар тогтоосон босго онооноос багагүй байх;

3.1.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;

3.1.4. Дээд боловсролтой элсэхийг хүсэгчийн бакалаврын диплом хүчинтэй, сурлагын голч дүн 2.6-аас доошгүй байх

3.2. Элсэхийг хүсэгч иргэн дараах тусгай шаардлагыг хангасан байна.

3.2.1. Эрэгтэй, 17-25 хүртэл насны, биеийн өндөр 168 см буюу түүнээс дээш,

3.2.2. Эмэгтэй, 17-20 хүртэл насны, биеийн өндөр 160 см буюу түүнээс дээш,

3.2.3. Энэ журмаар тогтоосон эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүй, ёс зүйн шалгуурыг хангасан байх;Тусгай шаардлага нь “Эрх зүй” хөтөлбөрт элсэхийг хүсэгч иргэнд хамаарахгүй.

Дөрөв. Элсэлтийн бүртгэл

А.Элсэхийг хүсэгч иргэн

4.1. Элсэхийг хүсэгч иргэдийн бүртгэл 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхэлж, 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 17.00 цагт дуусна.

4.2. Бүртгэл Хууль сахиулахын их сургуулийн www.leu.gov.mn хаягаар зөвхөн интернетээр /цаашид цахим гэх/ явагдах бөгөөд аймаг, орон нутагт тусгайлсан бүртгэл явагдахгүй.

4.3. Цахим бүртгэлд бүртгүүлэхдээ элсүүлэх хөтөлбөрүүдээс зөвхөн нэг хөтөлбөрийг сонгож, зааврын дагуу хувийн мэдээллээ бүрэн, зөв оруулж баталгаажуулна. Бүртгэлийн мэдээллийг бүрэн бус, дутуу оруулсан, 2 буюу түүнээс дээш хөтөлбөр сонгон бүртгүүлсэн тохиолдолд элсэхийг хүсэгчээр бүртгэхгүй.

4.4. “Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрийн 3 жилийн сургалтад элсэхийг хүсэгч дээд боловсролтой иргэн цахим бүртгэлд бүртгүүлэхгүй бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийг дуустал ажлын өдрүүдэд 14.00-16.00 цагийн хооронд Их сургуулийн байрлалд биечлэн ирж бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/
- Төрийн албан хаагчийн анкет /маягт 1/
- Бакалаврын диплом, хавсралт /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/
- 3x4 хэмжээтэй цээж зураг 4 хувь

Б. Элсэхийг хүсэгч албан хаагч

4.5. Элсэхийг хүсэгч алба хаагч цахим бүртгэлд бүртгүүлэхгүй.

4.6. Захиалагч агентлаг, байгууллагын алба хаагч энэ журамд заасан хөтөлбөрт элсэх хүсэлтээ харьяа байгууллагаараа уламжлуулан ирүүлнэ. Харьяа байгууллагын хүний нөөц, сургалтын асуудал эрхэлсэн нэгжээс суралцуулах зөвшөөрөл өгөөгүй алба хаагчийг бүртгэхгүй.

4.7. Захиалагч агентлаг, байгууллагуудын хүний нөөц, сургалтын асуудал эрхэлсэн нэгж бакалаврын хөтөлбөрийн 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч албан хаагчдын нэрсийн жагсаалт, өмнө эзэмшсэн бакалаврын дипломын хуулбарыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний дотор, өдрийн болон эчнээ 5 жилийн сургалтад элсэхийг хүсэгч алба хаагчдын нэрсийн жагсаалт, элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн хуулбарыг 2017 оны 07 дугаар сарын 05-ны дотор тус тус Комисст ирүүлнэ.

Тав. Элсэлтийн нэмэлт шалгалтын зохион байгуулалт

А.Элсэхийг хүсэгч иргэн

5.1.Цахим бүртгэлд бүртгүүлсэн элсэхийг хүсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор эрэмбэлсэн чансааны жагсаалтыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 14.00 цагаас өмнө гаргаж, нэмэлт шалгалтад орох чансааны оноог Их сургуулийн www.leu.gov.mn цахим хуудсаар, нэмэлт шалгалтад орох эрхтэй элсэхийг хүсэгчдэд бүртгүүлсэн цахим хаяг /e-mail/-аар тус тус мэдээлнэ.

5.2.Элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог хангасан боловч чансааны оноогоор энэ журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад дурдсан нэмэлт шалгалтад орох эрх бүхий элсэхийг хүсэгчдийн нэрсийн жагсаалтад багтаагүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасах ба нэмэлт шалгалтад оруулахгүй.

5.3.“Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрийн 3 жилийн сургалтад элсэхийг хүсэгч дээд боловсролтой иргэдийн бакалаврын сургалтын голч дүнгээр эрэмбэлсэн чансааны жагсаалт, холбогдох мэдээллийг мөн адил мэдээлнэ.

5.4. 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 03-ны өдрүүдэд Их сургуулийн байрлалд нэмэлт шалгалтад орох эрхтэй элсэхийг хүсэгчдэд шалгалтын хуудас олгоно. Аймаг, орон нутгийн харьяалалтай элсэхийг хүсэгчдэд мөн энэ хугацаанд Их сургуулийн байрлалд шалгалтын хуудас олгох бөгөөд нийслэлээс бусад аймаг, орон нутагт шалгалтын хуудас олгохгүй.

5.5. Шалгалтын хуудсыг биечлэн ирсэн элсэхийг хүсэгчдэд олгох бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж ирнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
- Дээд боловсролтой иргэний хувьд бакалаврын диплом, хавсралт, /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
- 2017 оноос өмнө Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн бол батламж шаардахгүй;
- 3x4 хэмжээтэй цээж зураг 4 хувь.

5.6. “Эрх зүй” хөтөлбөрт элсэхийг хүсэгч нэмэлт шалгалт өгөхгүй тул чансааны оноог хангасан элсэхийг хүсэгчид 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Их сургуулийн байрлалд энэ журмын 5.5-д заасан баримт бичгийг бүрдүүлэн ирж бүртгэлээ баталгаажуулна.

5.7. 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд эрүүл мэндийн үзлэгийг Их сургуулийн байрлалд зохион байгуулна. Эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн ерөнхий шалгуурыг хангаагүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасч, дараагийн нэмэлт шалгалтад оруулахгүй.

5.8. Бие бялдрын шалгалтыг 2017 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд дараах шалгуурын дагуу зохион байгуулна.

Эрэгтэй

д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр суниалт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	62	3.15	14.00	115	65	20
2.	60	3.20	14.10	114	64	19
3.	58	3.25	14.20	113	63	18
4.	56	3.30	14.30	112	62	17
5.	54	3.35	14.40	111	61	16
6.	52	3.40	14.50	110	60	15
7.	50	3.45	14.60	109	59	14
8.	48	3.50	14.70	108	58	13
9.	46	3.55	14.80	107	57	12
10.	44	4.00	14.90	106	56	11
11.	42	4.05	15.00	105	55	10
12.	40	4.10	15.10	104	54	9
13.	39	4.15	15.20	103	53	8
14.	38	4.20	15.30	102	52	7
15.	37	4.25	15.40	101	51	6
16.	36	4.30	15.50	100	50	5
17.	35	4.35	15.60	99	49	4
18.	34	4.40	15.70	98	48	3
19.	33	4.45	15.80	97	47	2
20.	32	4.50	15.90	96	46	1

Эмэгтэй

д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр суниалт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	40	3.50	15.00	90	65	20
2.	38	3.55	15.10	89	64	19
3.	36	3.60	15.20	88	63	18
4.	34	4.00	15.30	87	62	17
5.	32	4.05	15.40	86	61	16
6.	30	4.10	15.50	85	60	15
7.	28	4.15	15.60	84	59	14
8.	26	4.20	15.70	83	58	13
9.	24	4.25	15.80	82	57	12
10.	22	4.30	15.90	81	56	11
11.	18	4.35	16.00	80	55	10
12.	16	4.40	16.10	79	54	9
13.	14	4.45	16.20	78	53	8

14.	12	4.50	16.30	77	52	7
15.	10	4.55	16.40	76	51	6
16.	8	4.60	16.50	75	50	5
17.	6	5.00	16.60	74	49	4
18.	4	5.05	16,70	73	48	3
19.	2	5.10	16,80	72	47	2
20.	1	5.15	16,90	71	46	1

5.9. Бие бялдрын шалгалтын чанар тус бүрийг 20, нийлбэр 100 оноогоор дүгнэх ба нийлбэр онооны 50 буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцэнэ. Бие бялдрын шалгалтад тэнцээгүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасч, дараагийн нэмэлт шалгалтад оруулахгүй.

5.10. Бие бялдрын шалгалтын оноо элсэхийг хүсэгчдийн чансааны эрэмбэд нөлөөлөхгүй.

5.11. Эрүүл мэнд, бие бялдрын нэмэлт шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгчдийн чансааны онооны буурах эрэмбээр жагсааж, Их сургуулийн элсэлтийн мэдээллийн самбар болон www.leu.gov.mn цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

5.12. Хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчид цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдана. Хяналтын тоонд багтаагүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасах ба дараагийн сургалт, бэлтгэлд хамрагдахгүй.

5.13. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтыг Их сургуулийн Сургалт, дадлагын төвд 2017 оны 08 дугаар сарын 25-ны дотор багтаан 4-өөс доошгүй долоо хоногийн хугацаатай зохион байгуулна.

5.14. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдах элсэхийг хүсэгчид дараах баримт бичгийг бүрдүүлэн 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 09.00 цагт Их сургуулийн байрлалд биечлэн ирнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх
- Эрүүл мэндийн даатгалын дэвтэр /2017 оны 09 дүгээр сар хүртэл хугацааны даатгалыг бүрэн төлсөн байх/;
- Гэнэтийн ослын даатгалд хамрагдахтай холбогдох баримт бичиг

5.15. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад суралцахтай холбогдох зардлыг элсэхийг хүсэгч хариуцан төлнө. Сургалтын явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтыг орхисон, сахилгын зөрчил гаргасан, Сургалтын төвийн даргын зөвшөөрөлгүй байрлалыг орхин явсан элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасах ба элсүүлэн суралцуулахгүй. Энэ тохиолдолд бэлтгэл сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

5.16. Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар бүртгэлээс хасагдсан элсэхийг хүсэгчийн бэлтгэл сургалтад хамрагдсан хугацааны зардлыг суутган, үлдэгдэл төлбөрийг буцаан олгоно.

5.17. Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдаж байгаа элсэгчдийн сэтгэл зүй, зан байдал, төлөвшил, ёс зүйн судалгааг 2017 оны 08 дугаар сарын 20-ны дотор захиалагч агентлаг, байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.18. Судалгаагаар төрийн тусгай албанд тэнцэхгүй гэж дүгнэсэн элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасах ба элсүүлэн суралцуулахгүй.

Зургаа. Захиалагч агентлаг, байгууллагын алба хаагчдын элсэлтийн шалгалтын зохион байгуулалт

6.1. Захиалагч агентлаг, байгууллагаас ирүүлсэн бакалаврын хөтөлбөрийн 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч дээд боловсролтой алба хаагчдын элсэлтийн шалгалтыг 2017 оны 06 дугаар сарын 05-наас 09-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулна.

6.2. Элсэхийг хүсэгчдийг суурь болон хавсарга шалгалтын нийлбэр оноогоор буурах эрэмбээр жагсааж, хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтсан алба хаагчдыг элсүүлнэ.

6.3. Бакалаврын хөтөлбөрийн 4 жилийн өдөр, 5 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч алба хаагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтын чансааны онооны эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

6.4. Элсэхийг хүсэгч алба хаагчдаас нэмэлт шалгалт авахгүй.

Долоо. Элсүүлэх шийдвэр гаргах

7.1. Комиссын хуралдаанаар элсэлтийн шалгалтын дүнг хэлэлцэн, шалгуур хангаж, шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгчдийг сонгосон хөтөлбөрт элсүүлэн суралцуулах саналыг Их сургуулийн захиралд танилцуулна.

7.2. Бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах тухай Комиссын саналыг үндэслэн Их сургуулийн захирал тушаал гаргана.

7.3. Алба хаагчдыг элсүүлэн суралцуулах тухай тушаалыг 2017 оны 07 дугаар сарын 20-ны дотор, иргэдийг элсүүлэн суралцуулах тухай тушаалыг 2017 оны 08 дугаар сарын 25-ны дотор гаргаж, захиалагч агентлаг, байгууллагад мэдэгдэнэ.

Найм. Бусад зүйл

8.1. Элсэхийг хүсэгч иргэн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч элсэлтийн шалгалтын үйл явц, комиссын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлоо Их сургуулийн захиралд хандан гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ